

2023 ОНЫ 03 ДУГААР САРЫН 21-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2023 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2023 ОНЫ 03 ДУГААР САРЫН 21-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААН



ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

*Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.*

ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
2023 оны 03 дугаар сарын 21-ний өдөр, Мягмар гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	1
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	1-3
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	4-14
1.Байнгын хорооны тогтоолын төсөл /Хаврын ээлжит чуулганы 03 дугаар сард хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай/	4
2.Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл /Засгийн газар 2022.12.21-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	5-14

2023 ОНЫ 03 ДУГААР САРЫН 21-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

**Монгол Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы
Төсвийн байнгын хорооны 03 дугаар сарын 21-ний өдөр
/Мягмар гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Төсвийн байнгын хорооны дарга Г.Тэмүүлэн ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 19 гишүүнээс 10 гишүүн хүрэлцэн ирж, 52.6 хувийн ирцтэйгээр хуралдаан 12 цаг 29 минутад Төрийн ордны “Их эзэн Чинрис хаан” танхимд эхлэв.

Томилолттой: С.Ганбаатар, Б.Пүрэвдорж, Ц.Сандаг-Очир;
Чөлөөтэй: Ц.Анандбазар, Х.Баделхан, Д.Өнөрболор, Ч.Хүрэлбаатар;
Эмнэлгийн чөлөөтэй: Ш.Раднаасэд, Б.Чойжилсүрэн.

Нэг.Байнгын хорооны тогтоолын төсөл /Монгол Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы 03 дугаар сард Төсвийн байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төсвийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Э.Алтанзул байлцав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Г.Тэмүүлэн: “Монгол Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы 03 дугаар сард Төсвийн байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явууля.

Зөвшөөрсөн:	6
Татгалзсан:	4
Бүгд:	10

60.0 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 12 цаг 32 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл /Засгийн газар 2022.12.21-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн дэд сайд М.Ганхүлэг, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ц.Болорчулуун, мөн яамны Газар тариалангийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Д.Есөн-Эрдэнэ, Төрийн захиргаа удирдлагын газрын Хуулийн хэлтсийн дарга Э.Цолмонжаргал, Хөдөө аж ахуйг дэмжих сангийн гүйцэтгэх захирал Б.Цогтсаран, Бодлого, төлөвлөлтийн газрын ахлах мэргэжилтэн Б.Уранчимэг нар оролцов.

2023 ОНЫ 03 ДУГААР САРЫН 21-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх С.Дунжидмаа, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төсвийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Э.Алтанзул нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаар илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн, Барилга, хот байгуулалтын сайд Ц.Даваасүрэн танилцуулав.

Илтгэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал, Г.Амартүвшин, Г.Тэмүүлэн нарын тавьсан асуултад Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ц.Болорчулуун хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал, Г.Тэмүүлэн нар үг хэлэв.

Г.Тэмүүлэн: Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанд оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 5
Татгалзсан: 5
Бүгд: 10
50.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Ц.Даваасүрэнгийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Г.Тэмүүлэн: Улсын Их Хурлын гишүүн Ц.Даваасүрэнгийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 4
Бүгд: 10
60.0 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Г.Тэмүүлэн: Горимын санал дэмжигдсэн тул дээрх саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулья.

Зөвшөөрсөн: 5
Татгалзсан: 5
Бүгд: 10
50.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Ц.Даваасүрэнгийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Г.Тэмүүлэн: Улсын Их Хурлын гишүүн Ц.Даваасүрэнгийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6

2023 ОНЫ 03 ДУГААР САРЫН 21-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

Татгалзсан: 4
Бүгд: 10
60.0 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Г.Тэмүүлэн: Горимын санал дэмжигдсэн тул дээрх саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулья.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 4
Бүгд: 10
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ж.Батсуурь Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Байнгын хорооны хуралдаанаар 2 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 42 минут үргэлжилж, 19 гишүүнээс 10 гишүүн хүрэлцэн ирж, 52.6 хувийн ирцтэйгээр 13 цаг 11 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ТӨСВИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Г.ТЭМҮҮЛЭН

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ ХӨТЛӨХ
АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

П.ОЮУНГЭРЭЛ

2023 ОНЫ 03 ДУГААР САРЫН 21-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2023 оны 03 дугаар сарын 21-ний
өдөр, Мягмар гараг
Төрийн ордон “Их эзэн Чингис хаан”
танхим
12 цаг 29 минут.

**ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ**

Г.Тэмүүлэн: Байнгын хорооны гишүүддээ энэ өдрийн мэндийг хүргэе.

Байнгын хорооны хуралдаанд оролцож байгаа гишүүдийн ирцийг та бүхэнд танилцуулъя.

Одоогийн байдлаар 10 гишүүн хүрэлцэн ирсэн байна. Ирцийн мэдээлэл байна уу. Өнөөдрийн Байнгын хорооны хуралдаанд Ганибалын Амартүвшин, Жигжидийн Батжаргал, Жамбын Батсуурь, Хүрэлбаатарын Булгантуяа, Цэрэнпилийн Даваасүрэн, Болдын Жавхлан, Лхагвын Мөнхбаатар, Салдангийн Одонтуяа, Дуламдоржийн Тогтохсүрэн, миний бие гээд нийт 10 гишүүн хүрэлцэн ирсэн байна.

Ингээд 2023 оны 03 дугаар сарын 21-ний өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье.

Та бүхэнд Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. Өнөөдрийн хэлэлцэх асуудал 2 асуудал байгаа.

Эхний асуудал “Монгол УИХ-ын 2023 оны хаврын чуулганы ээлжит 3 дугаар сард Төсвийн байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл байгаа.

2 дугаар асуудал. ЗГ-ын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн ЗГ-ын тусгай сангийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл байгаа. ЗГ 2022 оны 12 дугаар сарын 22-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх асуудал байна.

Ингээд хэлэлцэх асуудалтай холбогдуулж саналтай гишүүд байна уу. Алга байна. Хэлэлцэх асуудалдаа орцгооё.

Нэгдүгээр асуудал. **“Монгол УИХ-ын 2023 оны хаврын ээлжит чуулганы 3 дугаар сард Төсвийн байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцэж эхэлье.**

Ингээд Байнгын хорооны цаглаварын төслийг та бүхэнд бас бэлтгэн тараасан байгаа. Ингээд Байнгын хорооны тогтоолын төсөлтэй холбогдуулан асуух асуулттай гишүүд байна уу. Алга байна.

Байнгын хорооны тогтоолын төсөлтэй холбогдуулан үг хэлэх гишүүд байна уу. Алга байна.

Ингээд санал хураалтыг явуулъя. “Монгол УИХ-ын 2023 оны хаврын ээлжит чуулганы 3 дугаар сард Төсвийн байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай” Байнгын хорооны тогтоол хуулийн төслийг баталъя гэсэн томъёолоор санал хураалтыг явуулъя. Санал хураалт.

Гишүүд анхааралтай байгаарай. Даваасүрэн гишүүн.

60 дэмжсэнээр тогтоолын төслийг хэлэлцэж шийдвэрлэлээ.

12.32 цаг

Дараагийн асуудалд орцгооё.

2023 ОНЫ 03 ДУГААР САРЫН 21-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

2. ЗГ-ын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн ЗГ-ын тусгай сангийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг хэлэлцэж эхэлье.

Төсөл санаачлагчийн илтгэлийг Жавхлан сайд танилцуулна гэсэн. Жавхлан сайд байна уу. Өөр сайд нар байна уу. Даваасүрэн гишүүн танилцуулчих уу.

Төсөл санаачлагчийн илтгэлийг БХБ-ын сайд Даваасүрэн гишүүн танилцуулна.

Ц.Даваасүрэн: Монгол УИХ-аас Алсын хараа 2050, шинэ сэргэлтийн бодлого зэрэг салбарын хөгжлийг дэмжих урт, дунд хугацааны хөгжлийн бодлогыг баталсан. Энэхүү бодлогын хүрээнд ХХААХҮ-ийн салбарт УИХ-д өргөн мэдүүлж яаралтай горимоор батлуулах шаардлагатай 3 хуулийн төслийн нэг нь ЗГ-ын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл юм. ХХААХҮ-ийн салбарын бодлого нь ХАА-н гаралтай түүхий эд бүтээгдэхүүний нөөцийг эдийн засгийн эргэлтэд эрчимтэй оруулах нөхцөлийг бүрдүүлж, ДНБ үйлдвэрлэл салбарын үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх эрчимжсэн МАА-г хот суурин орчимд бүсчлэн хөгжүүлж, нөөцийг тогтвортой, зохистой ашиглан хүн амыг эрүүл бүтээгдэхүүнээр тасралтгүй хангахад чиглэгдэж байна. Энэхүү бодлого зорилтыг хэрэгжүүлэхийн тулд төрийн зарим чиг үүргийн хүрээнд улсын төсвийн хөрөнгөөр хийгдэж байгаа таримал ургамлын үр суулгац, сортын үрийг үржүүлэг, ургамал хамгааллын бодис, бордоо, шатахууны импортын худалдаа, ХАА-н техник тоног төхөөрөмжийн дилерийн болон түрээсийн үйлчилгээ, засвар, сэлбэг хэрэгслийн худалдаа, эрчимжсэн МАА-г дэмжих ХАА-н зөвлөх нэвтрүүлэх үйлчилгээ зэрэг ажил

үйлчилгээг аж ахуйн тооцоонд шилжүүлж, өөрөө өөрийгөө санхүүжүүлэх хэрэгцээ шаардлага үүсэж байна.

Цаашилаад ХАА-н үйл ажиллагаа эрхлэгчдийн орлого нэмэгдүүлэх тэдгээрийн зах зээлийн бодит эрэлт хэрэгцээнд тулгуурласан бүтээгдэхүүн, үйлчилгээг бий болгох, шударга хүртээмжтэй хуваарилалтын тогтолцоог бүрдүүлэх, ХАА-н үйлдвэрлэлийн технологитой уялдсан тасралтгүй нийлүүлэлтийн сүлжээг бий болгох, дотоодын үйлдвэрлэгчдэд санхүүгийн дэмжлэг үзүүлэх боломж бүрдүүлэх зорилгоор аж ахуйн тооцоотой ТӨК байгуулах нь зүйтэй гэж үзсэн.

Энэхүү ТӨК нь Компанийн тухай болон бусад холбогдох хууль тогтоомжийн хүрээнд ашигт ажиллагаа, хөрөнгийн ашиглалтыг сайжруулах, улсын төсөвт учруулж буй өрийн дарамтыг бууруулах, ХАА-н салбарт олгох дэмжлэгийн нэр төрөл, тоо хэмжээ, хүртээмжийг нэмэгдүүлэх, өрсөлдөх чадварыг бий болгох зэрэг олон эерэг үр дүн үзүүлэх боломжтой юм. Үүний зэрэгцээ ХАА-н үйлдвэрлэл эрхлэгчид тэдний эрэлт хэрэгцээнд нийцсэн таримал ургамлын үр, сорт, бордоо, ургамал хамгааллын бодис, шатахуун, газар тариалангийн тоног төхөөрөмж, усалгааны багаж хэрэгслийг хямд үнээр тариалантын технологийн хугацаанд нийлүүлэх болно.

Мөн үйлдвэрлэлийн менежментийг сайжруулан шаардлагатай засвар үйлчилгээг цаг тухайд нь хийх, буудайн хадгалалтын нөхцөл сайжрах цаашилаад үр ашиг нэмэгдэнэ гэж тооцож байна.

Иймд дээр дурдсан ач холбогдлыг харгалзан ЗГ-ын тусгай сангийн тухай хуулийн ХАА-г дэмжих сан болон уг санг эшилсэн бусад заалтуудыг хасах замаар ХАА-г дэмжих санг татан буулгах ЗГ-ын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт

2023 ОНЫ 03 ДУГААР САРЫН 21-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

оруулах тухай хуулийн төслийг боловсруулан танилцуулж байна. Хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү.

Г.Тэмүүлэн: Даваасүрэн сайдад баярлалаа.

Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг та бүхэнд танилцуулъя.

Цэндгомбын Болорчулуун ХХААХҮЯ-ны Бодлого төлөвлөлтийн газрын дарга, Даваасүрэнгийн Есөн-Эрдэнэ ХХААХҮЯ-ны Газар тариалангийн бодлого эрхлэлтийг зохицуулах газрын дарга, Энхбаатарын Цолмонжаргал ХХААХҮЯ-ны Хуулийн хэлтсийн дарга, Батжаргалын Цогтсаран ХАА-г дэмжих сангийн гүйцэтгэх захирал, Базаррагчаагийн Уранчимэг ХХААХҮЯ-ны Бодлого төлөвлөлтийн газрын ахлах мэргэжилтэн гэсэн байна. ХХААХҮЯ-ны дэд сайд Ганхүлэг оролцож байна.

Хуулийн төслүүдтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу? Нэрсийг авъя. Амартүвшин гишүүнээр тасаллаа. Батжаргал гишүүний микрофоныг өгье.

Ж.Батжаргал: Тэгэхээр өргөн баригдаж орж ирж байгаа хуулийн төслүүдийг ерөнхийд нь харсан. Хууль зүйн техник хэллэг тэр юмнууд нь хэрхэн нийцэж байгаа юм. Түүнийг нэг анхаарах ёстой болов уу гэж ингэж бодоод байгаа.

2 дахь зүйл. Төрийн өмчтэй тэр компани одоогийн ХАА-г дэмжих сангийн чиг үүргийг хэрэгжүүлж, аж ахуйн тооцоотой үйл ажиллагаа явуулах юм байна гэж ингэж ойлгож байгаа. Тэгэхээр зэрэг энэ газар тариалан, МАА-н үйлдвэрлэл, түүний хослол буюу тэр эрчимжсэн МАА-н салбарын хөгжлийг хангах чиглэл дээр уг төрийн өмчтэй аж ахуйн байгууллагын дүрэм юманд ер нь ямархуу байдлаар юм тусаж орж байгаа вэ. ХАА-н салбарын ажил гэдэг бол технологийн цаг хугацаатай ийм ажлууд байгаад байдаг аа. Хаврын тариалалтын бэлтгэл ажил хаяанд ирсэн байна. Тийм

учраас эдийн засгийн энэ үндсэн салбар болсон амь амьжиргаа болсон салбарынхаа үйлдвэрлэлийн гол технологийн цаг хугацааны үед ямарваа нэгэн хүндрэл гаргахгүй аваад явах ийм бололцоо, боломж, бэлтгэл, зохион байгуулалтыг хэрхэн хангасан юм бэ гэдэг нэг ийм асуудал байгаад байгаа.

Дараагийн нэг асуудал нь яах аргагүй энэ өргөн баригдаад ороод ирж байгаа хуулиудыг дагуулж түрүүний миний ярьж байгаа тэр цаг үеийн ажил асуудлуудын бэлтгэл хангах. Ер нь ХАА-г дэмжих сангийн тэр чиг үүргийг уг компаниар хэрэгжүүлэх тийм зохицуулалтыг нь бий болгосон дагасан тогтоолыг Их Хурлаас гаргаж өгч байж ямарваа нэгэн хийдэлгүй үйл ажиллагаа явагдах ийм бололцоо боломж бүрдэнэ гэж ингэж харж байна аа. Энэ талаар төсөл өргөн баригч ямархуу байр суурь чиглэлтэй байна вэ гэдэг асуудал.

Одоо ХАА-г дэмжих сан дээр байж байгаа нийт хөрөнгө, өр авлагын асуудлууд уг шинээр байгуулагдаж байгаа компани руу албан ёсоор бүгд шилжих ёстой юу? Цаашид ЗГ хоорондын хэлэлцээрээр буцалтгүй тусламжаар гэдэг юм уу хөнгөлөлттэй зээлээр ХАА-н салбарыг дэмжих үйл ажиллагаанд орж ирж байгаа бүхий л асуудлууд энэ аж ахуйгаар дамжих, дээр нь улсын төсөв дээр бид нар тодорхой хөрөнгүүд тавьж эхэлсэн. Дан дамаа газар тариалангийн салбар дээр тэр стратегийн хүнс болсон улаан буудайн стратегийн нөөц технологийн нөөц бүрдүүлэлт дээр тодорхой хөрөнгүүд тавьж байгаа. Энэ асуудлуудыг энэ компаниар гүйцэтгүүлээд явах ямарваа нэгэн эрх зүйн зөрчил гэдэг юм уу саад тотгор гарахгүй байх тийм эрх зүйн боломж чадамж нь байгаа юу гэдэг дээр хариултуудыг авмаар байна.

Г.Тэмүүлэн: Батжаргал гишүүний асуултад хариулъя. Хэн хариулах вэ? Болорчулуун дарга 3 дугаар микрофон.

2023 ОНЫ 03 ДУГААР САРЫН 21-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Болорчулуун. Батжаргал гишүүний асуултад хариулья. Тэгэхээр энэ ЗГ-ын тусгай сангийн үйл ажиллагаа нь хуучин тусгай сангийн тухай хуулиар зохицуулагдаж байсан. Ингэхдээ ХАА-г дэмжих сан нь нийтдээ 7 чиглэлийн үйл ажиллагаа явуулдаг байсан. Одоо бол бид нар энэ үйл ажиллагаа ерөнхийдөө Сангийн явж байгаа үйл ажиллагаа нь энэ яг явж байгаа энэ зах зээлийн нийгэмдээ явах нь бас тийм тохиромжтой биш гэдэг ийм дүгнэлтэд хүрсэн учраас 100 хувь хувьцааг нь ХААЯ эзэмшигч ийм ТӨК-ийг байгуулсан байгаа юм. Нэр нь ХАА-н корпорац ТӨК гээд. Тэгэхээр энэ компанийн хувьцааг нь 100 хувь эзэмшигч ХААЯ байгаа. Тийм учраас энэ яамны сайдын харьяалах эрхлэх асуудлын хүрээнд энэ компани үйл ажиллагаагаа явуулна.

Ингэснээр компанийн дүрмийг компани байгуулагдсан, компанийн дүрмийг байгуулсан. Тэгэхээр одоо явж байгаа энэ зах зээлийн нийгэмтэйгээ уялдуулаад ер нь энэ салбарт үзүүлж байгаа дэмжлэг бусад арга хэмжээнүүдийг хэрхэн яаж зохион байгуулах вэ гэдэг тал дээр хуучин явж байсан 7 үйл ажиллагааны чиглэлийг бид нар 16 болгож компанийн дүрэмд өөрчлөлт оруулсан. Тэгэхээр энэ одоо компани татан буугдсан, сан татан буугдсанаар хөрөнгө нь компани руу шилжээд энэ компанийн үйл ажиллагаа энэ салбарын бодлого, чиглэлийг хэрэгжүүлээд явахад ямар нэгэн доголдол гарахгүй гэж ингэж үзэж байгаа. Тухайлах юм бол бид нар МАА-н салбарын чиглэлд газар тариалангийн салбарын чиглэлд тэгээд энэ инновац технологийн чиглэлийн бусад энэ шинээр гарч ирж байгаа зөвлөх үйлчилгээ энэ тэрийг энэ компаниар дамжуулж явуулья гэдэг нийт ийм 16 чиглэлийг компанийн дүрэмд тодорхой тусгаад өгчихсөн байж байгаа. Ингэж энэ компанийн үйл ажиллагааг өргөжүүлсэн байгаа. Тийм учраас энэ ямар нэгэн доголдол гарахгүй гэж үзэж байгаа.

Санг татан буулгаснаар ЗГ-ын ишийдвэр гарч сангийн баланст байгаа эргэлтийн хөрөнгө, үндсэн хөрөнгө болон бусад өр төлбөрүүд энэ компани руу 100 хувь шилжих ийм зохицуулалттайгаар явж байгаа.

Авлага барагдуулалт дээр бид нар харин энэ ААН-үүдтэй хэрвээ энэ компани болоод явчих юм бол бусад хуулийн байгууллага хуулийн этгээдүүдтэй өр авлага барагдуулах гэрээ байгуулах ч юм уу ийм замаар энэ авлагуудыг барагдуулах ийм боломжууд бас үүснэ гэж харж байгаа.

Дээрээс нь тэгээд хуучны ТТ сан Мал хамгаалах сан 2 нэгдээд ХАА-г дэмжих сан болчихсон юм. Жижиг дунд ороогүй.

Г.Тэмүүлэн: Батжаргал гишүүн тодруулах уу? Амартүвшин гишүүн асуулт асууя.

Г.Амартүвшин: Баярлалаа. Ер нь миний ойлгосноор ХАА-г дэмжих санг л хэлбэрийг нь өөрчилж корпорац болгож байна л гэж харж байна шүү дээ. Үгүй ээ, тэгээд компанийн юунд хэлбэрт тэгээд шилжээд юу өөрчлөгдөх юм, ер нь. ХАА-н дэмжих сангийн үйл ажиллагааг харахад нэлээн л тийм учир дутагдалтай л харагдаад байгаа шүү дээ. Ер нь манай ЗГ-ын энэ ХАА-н салбарт хэт оролцоогоос болоод энэ ХАА чинь бас хөгжихгүй байгаа нэг шалтгаан шүү дээ. Тэгэхээр энэ корпорац сангаас корпорац руу шилжихээр тэр сайн, муу бүх хөрөнгө нь шилжинэ гэж ойлгоод байгаа шүү дээ. Үгүй ээ, тэгж шилжлээ гээд тэр төлөгдөхгүй байгаа тэр зээлд гаргасан дэмжлэгүүд чинь яаж өөрчлөгдөх юм. Үүнийг би ерөөсөө ойлгохгүй байна л даа.

2 дугаарт, хэрвээ үнэхээр ХАА-гаа дэмжье гэсэн та нар дизель түлшний үнэ дээрээ л дэмжих ёстой байсан шүү дээ. Тэр боломжоо алдчихсан шүү дээ. Дизель түлшний үнэ чинь чөлөөтэй л ингээд л хэлбэлзээд явж байна. Хамгийн өндөр

2023 ОНЫ 03 ДУГААР САРЫН 21-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

үнэтэй, яг Монгол Улсын эдийн засгийг тэжээдэг гол түлшний хэлбэр нь дизель түлш шүү дээ. 92-оо бариад байдаг, дизелиэ тэгээд чөлөөтэй хаячихсан шүү дээ. Тэгэхээр би энэ дээр аягүй эргэлзээд байна л даа. Яг ингээд корпорац боллоо. Тэр 70 хэдэн албан хаагчдыг цомхотгоод 40, 48 болгоно гэлүү тийм ээ. Үгүй ээ, тэр хүмүүс чинь тэгээд яаж тэр төлөгдөхгүй байгаа зээлийг төлүүлэх юм? Яаж хөөцөлдөх юм? Үгүй ээ, компанийн хэлбэрийг нь сангийн хэлбэрийг нь өөрчилснөөр компани болсноор яг юу өөрчлөгдөх юм? Тэрийг би ерөөсөө ойлгохгүй байгаад байгаа юм.

2 дугаарт, яг улаан буудайн зах зээл дээр бол төр засаг нь гаднаас Оросоос улаан буудай импортлоод л, дотоодын үйлдвэрлэгчдээ тариаланчдаа тэгээд л унагаагаад байгаа шүү дээ. Ноднин тиймэрхүү л юм болсон юм байна лээ шүү дээ. Тэгээд газар тариалан эрхэлдэг компаниудтай уулзахад бол. Ерөөсөө гаднаас юу оруулж ирээд л ноднингийн ургацаас хураасан улаан буудай чинь зарагдаагүй бас өчнөөн л улаан буудай байгаа л юм байна лээ шүү дээ. Тэгэхээр энэ үнийн зохицуулалт ингэдэг юм чинь бас зах зээлийн эрэлт нийлүүлэлтийн механизмыг бас эвдэж байгаа шүү дээ. Тэгэхээр энэ дээр илүү анхаарах нь чухал юм биш үү? Энэ компанийн хэлбэрийг өөрчилж корпорац болгосноор надад л лав тийм гэрэл гэгээтэй сайн юм харагдахгүй л байгаад байна л даа. Тайлбарлаж өгөөч.

Г.Тэмүүлэн: Амартүвшин гишүүний асуултад хариулья. Хэдэн номер вэ? 3 номер.

Ц.Болорчулуун: Амартүвшин гишүүний асуултад хариулья. Тэгэхээр ХХААХҮ-ийн салбарт яамны харьяанд үндсэндээ 3 сан үйл ажиллагаа явуулж ирсэн. 1 дүгээрт нь, Тариалан эрхлэлтийг дэмжих сан, ЗГ-ын тусгай сангийн тухай хуулиар энэ 3 сан зохицуулагдаж ирсэн байгаа. 1 дүгээрт нь Тариалан эрхлэлтийг дэмжих сан, 2 дугаарт нь, Мал хамгаалах

сан, дугаарт нь, ЖДҮХС гээд. Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан бол ЖДҮ-ийн газар агентлаг болоод ингээд үйл ажиллагааны чиглэл өөрчлөгдөөд явж байгаа. Төсвийн тухай хуулийг дагуулаад 2020 оны хуулийг дагуулж Мал хамгаалах сан, ТЭДС-г нэгтгэж ХАА-г дэмжих сан гэж энэ сан бий болгосон. ХАА-г дэмжих сангийн үйл ажиллагаа нь зөвхөн Засгийн газрын тусгай сангийн хуулийн хүрээнд үйл ажиллагаа явуулж ирсэн. Тэгэхээр төрөөс үзүүлж байгаа энэ салбарт үзүүлж байгаа дэмжлэгүүдийг сангаар тодорхой хэмжээнд дамжуулж олгодог, эргэн төвлөрүүлдэг, бусад гаднын зээл тусламжуудыг энэ сангаар дамжуулж олгож ирсэн. Тэгэхдээ энэ сан нь өөрөө ашигийн бус хуулийн хүрээнд энэ тусгай сангийн тухай хуулийн хүрээнд үйл ажиллагаа явуулж байсан учраас тодорхой хэмжээний бас алдагдлыг хүлээж ирсэн. Тэгээд энэ дээр бас тодорхой хэмжээний дүгнэлтийг гаргаад Сангийн яам, Хууль зүйн яамнаас энэ хуулийн төслийг үзэл баримтлалыг хамтарч батлаад ер нь цаашидаа энэ төсөвт ямар нэгэн дарамтгүйгээр тусдаа ийм хуулийн этгээдээр явах нь зүйтэй гэсэн ийм шийдвэрийг гаргаад энэ хуулийн төслийг боловсруулж оруулж ирж байгаа.

Цаашидаа компани болсноор Компанийн тухай хуулиар зөвхөн ашигтай ажиллах ийм зарчмыг баримтална. Энэ хүрээндээ үйл ажиллагаа явуулна гэж ингэж ойлгож байгаа юм аа. Тийм учраас үүнийг компани болгоод явах нь зүйтэй.

Одоо бид нар өр авлагаа барагдуулахад хийх тодорхой хэмжээнд шүүх дээр шүүхтэй хамтарч ажиллаж байгаа. Энэ дээр эргэн төлөлтүүд тодорхой хэмжээнд явж байна. Бусад хуулийн байгууллагууд, хуулийн фермүүдтэй хамтарсан гэрээ байгуулаад өр авлагаа барагдуулъя гэхэд л тийм боломжгүй байдаг нэг жишээ байна.

2023 ОНЫ 03 ДУГААР САРЫН 21-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

Дээрээс нь сангийн үйл ажиллагаанд байхаар энэ харьяанд нь байдаг үндсэн хөрөнгө болох 182000 тонны 6 байришлд байгаа элеваторууд байгаа. Элеваторуудын үйл ажиллагаа, засвар үйлчилгээг бид нар бас тогтмол хийх ийм нөхцөл боломж хомс байгаад байна. Тийм учраас энэ компани байгуулж үүнийгээ бас энэ буудайныхаа хадгалалт хамгаалалт дээр анхаарах, чанар стандартад анхаарах ийм боломжийг бүрдүүлье гэдэг ийм байдлаас компани болгож явж байгаа.

Улаан буудайг яг ЗГ яам импортолж оруулж ирдэггүй байгаа. Тухайн жилийн ургацын баланс бол хурааж авсан ургацын дүнг 10 сард, 11 сард ЗГ-т танилцуулаад дутагдах хэмжээний ургацыг шаардлагатай нөхцөлд гурилын үйлдвэрүүдэд оруулж ирэх импортын зөвшөөрлийг олгодог. Энэ жилийн тухайд бид нар бас тодорхой хэмжээний дотоодын хэрэгцээ хангахуйц хэмжээний буудай хурааж авсан хэдий ч яг гурилын үйлдвэрийн чанар стандартад тэнцэх хэмжээний буудайнаас нь бас 50 орчим мянган тонн буудай дутагдалтай байгаа. Үүнийг сонгон шалгаруулалтыг бас Хүнсний аюулгүй байдлын үндэсний зөвлөлд оруулж танилцуулснаар энэ гурилын үйлдвэрүүдэд олгож байгаа. Түүнээс сан яам энэ дээр төсвийн хөрөнгө мөнгө гаргаж буудай оруулж ирдэг асуудал байхгүй. Гурилын үйлдвэрүүдтэй энэ хамтын ажиллагааг зохицуулж дотоодын хангамжаа бүрдүүлэх тал дээр л анхаарч ажиллаж байгаа.

Г.Тэмүүлэн: Амартүвшин гишүүн тодруулъя.

Г.Амартүвшин: Одоогийн байдлаар ХАА-г дэмжих сангийн нийт хөрөнгө ямар хэмжээтэй байгаа вэ?

2 дугаарт, муу зээлийн хэмжээ нь хэд, хэдэн хувь, нийт дүн нь хэд байгаа юм? Дундаж хугацаа хэтрэлт нь хэдэн хоногтой байгаа юм. Тэр мэдээллийг өгнө үү.

2 дугаарт, саяын таны хариултаас би юу гэж ойлгож байна вэ гэхээр энэ шинээр байгуулагдаж байгаа корпорац элеватор өөрийнхөө баланс дээр авна гэсэн үг үү. Тэр элеваторуудыг өөрөөр хэлбэл энэ чинь өмнө нь цэвэр бараг санхүүгийн л үйл ажиллагаа явуулдаг, аж ахуй үйл ажиллагаа байсан бас үндсэн хөрөнгө элеватортой болно гэж ойлгоод байна шүү дээ.

Г.Тэмүүлэн: 3 номер Болорчулуун.

Ц.Болорчулуун: Тэгэхээр Амартүвшин гишүүний асуултад нэмэлт хариулт өгье. Одоо үйл ажиллагаа явуулж байгаа ЗГ-ын тусгай сан буюу ХАА-г дэмжих сангийн үндсэн хөрөнгөд энэ 6 байришлын элеватор байгаа. Үйл ажиллагаа явуулж байгаа. Энэ цаашдаа энэ сан татан буугдсанаар сангийн үндсэн болон эргэлтийн хөрөнгө бүгдээрээ энэ компани руу шилжинэ гэсэн үг. Тэгэхээр энэ шинээр авах гэж байгаа асуудал биш хуучин байгаа хөрөнгө нь шилжээд явна гэсэн үг. Зүгээр сан дээр нөгөө элеватор байгаад бид нар нөгөө төсөвт энэ байгууллага байгаа учраас засвар үйлчилгээнийхээ хөрөнгө мөнгийг ч тавьж чадахгүй байгаа. Тийм учраас энэ 1990-ээд оноос байгуулагдсан энэ элеваторуудыг бас засаж засвар үйлчилгээг явуулж энэ үрийн будаа болон хүнсний улаан буудайн чанар стандартыг хадгалах ийм зайлшгүй шаардлага байдаг учраас энэ чиглэлд явна гэж ... /минут дуусав/

Г.Тэмүүлэн: Нэмж хариулъя. 3 номер.

Ц.Болорчулуун: Нийт сангийн хөрөнгө нийтдээ 382.6 тэрбум төгрөгийн хөрөнгөтэй байгаа. Үүнээс авлагын дүн нийтдээ 217 тэрбум байгаа. Энэ ингээд дотор нь бид нар насжилтаар нь ингээд ангилаад явчихсан. Тухайлах юм бол 11-20 жилийн настай гэхэд нэг 17 орчим тэрбум төгрөг байгаа. Бусад зээлүүд нь 1-10 жилийн хугацаанд хугацаандаа явж байгаа зээлүүд байгаа. Хугацаа хэтэрсэн

2023 ОНЫ 03 ДУГААР САРЫН 21-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

нь нэг 18 тэрбум төгрөг, 18.5 орчим тэрбум төгрөгийн хугацаа хэтэрсэн зээлтэй байна.

Г.Тэмүүлэн: Гишүүд асуулт асуулаа.

Та хэд бас анхаарах юмнууд байна. Хэд хэдэн зүйл дээр. Нэмж нэг тодруулах 2, 3 асуудлууд байгаа. Саяын энэ шинэ корпорацыг байгуулах гэж байгаатай холбогдуулаад өмнөх энэ ЗГ-ын тусгай санг байхгүй болгож шинэ корпорац байгуулах гэж байгаатай холбогдуулаад энэ өөрөө шинээр байгуулагдаж байгаа корпорац байна уу, компани байна уу энэ байгууллага маань нэг талдаа бизнесийн зарчмаар чөлөөт зах зээлийнхээ зарчмаар, чөлөөт менежментийн хүрээнд гэдэг юм уу бие даасан хараат бус байдлаар ашгийн төлөө ажиллах ёстой гэж харж байгаа юм. Зарчим нь зөв үү? Тэгэхээр энэ үүднээс яг үүнийг тийм юу гэдэг юм явуулах боломж бололцоо, засаглал, менежмент талаасаа тийм боломж бололцоо байгаа юу? Би сая бас яг яамны доор компани байгуулна, корпорац байгуулна гэдэг асуудлыг бас гайхаад байгаа юм. Нэг талдаа бас өнөөдөр ч гэсэн хэд хэдэн яамнууд дээр компаниуд байна. Тэгэхээр яам өөрөө бодлогын яам, яам өөрөө бодлогынхоо ажлыг бодлогоо тодорхойлоод явах ёстой асуудлууд байгаа.

Тэгэхээр ямар нэг байдлаар аж ахуйн үйл ажиллагаанд нь оролцох ёсгүй асуудлууд байгаа. Тэгэхээр зүгээр яг энэ яам энэ компанийн хувьцаа эзэмшигч нь байх юм уу, ТУЗ-ийг нь бүрдүүлдэг байх юм уу? Засаглал талаас нь ер нь та хэд менежментийг нь яаж харж байгаа юм бэ? Бид нарын хүсэж байгаа зүйл яг үнэхээр корпорац байгуулж байгаа бол, компани байгуулж байгаа бол энэ өөрөө өмчлөл засаглал хэлбэрийг нь бид нар зөв байлгах ёстой гэж хараад байгаа юм. Тэгэхээр энэ дээр ямар бодлого баримтлах гээд байгаа юм. Бизнесийнхээ зарчмаар ажиллуулах боломж бололцоог нь яаж бүрдүүлэх гээд байгаа юм.

Компанийн засаглалыг нь яаж бүрдүүлэх юм, хувьцаа эзэмшил, эзэмшигч нар нь ямар түвшинд байх юм гэдэг юм уу эсвэл ТӨХ-н дээр байх юм уу эсвэл таны сая үгийн алдаа байсан уу. Яаман дээр шууд 100 хувь өмчлөл хамаарал нь яам хувьцааг нь 100 хувь эзэмшээд явах юм уу. Энэ тал дээр хариулах уу. Хэн хариулах вэ? 3 номер.

Ц.Болорчулуун: ЗГ-ын тогтоолоор ТӨК байгуулагдсан. Төрийн хувьцаа эзэмшигч нь бол ХАА, төрийн хувьцаа эзэмшигч нь эзэмшлийн хувьцаа эзэмшигч нь эрхийг хэрэгжүүлэгч нь ХХААХҮЯ байгаа. Тэгж тогтоосон.

Засаглалын хувьд бид нар ТӨБЗГ, ТУЗ-тэй байна гээд төлөөлөн удирдах зөвлөлийнхөө эрх, үүргийг энэ компанийн дүрэмд бусад төрийн өмчийн компаниудын адилаар тусгаж өгсөн байж байгаа. Засаглалын хувьд Компанийн тухай хуульд байх энэ ТУЗ-тэй байх, гүйцэтгэх захиралтай байх гээд энэ хувьцаа эзэмшигч нь хэн байх гэдэг энэ засаглалын бүх зарчмуудыг дүрэмд нь тусгаад өгчихсөн байж байгаа.

Г.Тэмүүлэн: Одоо яах вэ, зүгээр тэрийг нь ойлголоо. 2 дахь нь яг хуучин нөгөө энэ ХАА-г дэмжих сангаар ч гэдэг юм уу мал хамгаалах сангаар ч гэдэг юм уу өмнө орж ирж байсан хөнгөлөлт нэн хөнгөлөлттэй зээлүүд орж ирдэг байсан. Олон улсын байгууллагуудаас бусад ЗГ-аас. Миний санах энэ Беларусь улсын зээл орж ирсэн тийм ээ. Дээрээс нь БНХАУ-ын зээл орж ирж байсан. Өөр иймэрхүү жишээ нь юу гэдэг юм бид нар энэ олон улсын зээл, дэмжлэг хөнгөлөлттэй зээлүүдийг энэ нэг талдаа сан маань юу гэдэг юм, улс гэж төлөөлж харагдаж байгаа ЗГ-ынх гэж харагдаж байгаа үүднээсээ шууд зээл юунууд өгдөг байсан. Тэгэхээр компани болчихоор иймэрхүү гаднаас орж ирэх зээл дэмжлэг тусалцаа хөнгөлөлттэй энэ хөтөлбөрийн асуудлууд хэрэгжихэд хүндрэл учрах уу? Үүнийг эсвэл ЗГ дээр та

2023 ОНЫ 03 ДУГААР САРЫН 21-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

хэд бас яаж зохицуулна гэж харж байгаа юм.

Нөгөө талдаа юу гэдэг юм, магадгүй өмнөх энэ сангийн маань үндсэн үйл ажиллагаа нь газар тариалангаа дэмжих, МАА-г дэмжих энэ МАА үйл ажиллагааг эрхлэх үйл ажиллагааг дэмжих зориулалттай байсан. Одоо энэ сан байхгүй болчихоор энэ Батжаргал гишүүний хэлээд байгаа сангийн эрхэлж байсан бүх чиг үүрэг, үүрэг харцуцлагуудыг нь энэ компани аваад явна гэсэн үг үү. Аль аль үүргүүд нь юу гэдэг юм эсвэл байхгүй болоод зах зээлийнхээ зарчмаар бид нар бас хасах шаардлагатай, компанид ишлжүүлэхгүйгээр явах гэж явах ёстой гэж харж байгаа юм. Энэ дээр нэг тодорхой хариулт өгөөч гэж хэлэх гээд байгаа юм.

Ц.Болорчулуун: Тэмүүлэн гишүүний асуултад хариулъя аа. Тэгэхээр хуучин бас ЗГ-ын хөнгөлөлттэй зээлүүд дамжуулан зээлийн гэрээг байгуулаад Сангийн ямаар дамжуулан, дамжуулан зээлийн гэрээ байгуулаад энэ сангаар олгогдож байсан. Тухайлах юм бол Бүгд найрамдах Беларус улсын ЗГ-ын хоорондын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр 4.5 сая долларын техник тоног төхөөрөмжийг сангаар дамжуулж олгосон байдаг. Одоо эргэн төлөлтүүд нь хэвийн явагдаж байгаа.

Зүгээр цаашидаа энэ үйл ажиллагаа доголдох вий гэдэг дээр бид нар хуучин сангийн яг явуулах үйл ажиллагааны чиглэл 7 чиглэлд байсныг 16 болгож өргөжүүлсэн. Тэгэхээр энэ дээрээ бид нарт дутагдалтай байдаг нөгөө үйл ажиллагаанд хязгаарлагдмал байгаад байсан зүйлүүдээ энд тодорхой тусгаж өгсөн. Тухайлах юм бол бид нар энэ компанийн дүрмийн 5.2.6 дээр ХАА-н салбарт олгох дэмжлэгийн нэр төрөл, хүртээмжийг нэмэгдүүлнэ гээд, 5.2.9 дээр орлого нэмэгдүүлэхэд чиглэсэн хуулиар хориглоогүй бизнесийн үйл ажиллагаа явуулах гэх мэтчилэн ингээд нийтдээ 16

чиглэлийг энэ дотор МАА-н чиглэлийг нь тэгээд дээрээс нь шинэлэг энэ зөвлөх үйлчилгээ, инновац, шинэ технологи нэвтрүүлэх гээд энэ байдлуудыг бүгдийг нь ингээд оруулаад өгчихсөн. 5.2.3 дээр уламжлалт болон эрчимжсэн МАА, газар тариалан, үрийн аж ахуйг дэмжин хөгжүүлэх гээд гэх мэтчилэн бид нарт яг нэг хязгаарлагдаад байсан зүйлүүдээ энэ дүрэмдээ нэлээн сайн шигтгээж өгсөн учраас энэ бол харин хуучин сангийн үйл ажиллагаанаасаа илүү энэ ТӨК-аар үйл ажиллагаа явуулах нь энэ салбарын дэмжлэг энэ тэрийг хүртээмжтэй болгох тал дээр тодорхой ахиц дэвшил гарна гэж ингээж харж байгаа юм.

Г.Тэмүүлэн: Тэгэхээр энэ сан дээр байсан бүх хөрөнгө, өр төлбөр, авлага эд нар бүгд энэ корпорац руу ишлжинэ гэж ойлгож байгаа тийм ээ. Тэгэхээр энэ дээр та хэд маань бас яг тодорхой саяын тэр Амартүвшин гишүүний асууснаар яг саяын тэр авлага нь болоод бараа материал нь ч гэдэг юм уу эсвэл өр төлбөрийн дүн үзүүлэлтүүд нь ямар байгаа талаар тодорхой мэдээллүүдийг өгөөдхөөч, протоколд тусгах үүднээс.

3 номер Болорчулуун.

Ц.Болорчулуун: Сангийн энэ санхүүгийн үзүүлэлтийн талаар товч танилцуулъя. Тэгэхээр нийт эргэлтийн хөрөнгө 299.1 тэрбум байгаа. Энэ бол нийт хөрөнгийн 78.2%, харилцахын үлдэгдэл 3.5 тэрбум 0.9%, авлагын дүн 217.2 тэрбум нийт эзлэх хувь нь 56.8%, бараа материал 78.3 тэрбум 20.5%, үндсэн хөрөнгө 83.5 тэрбум буюу 21.8 гээд нийтдээ 382.6 тэрбум төгрөгийн нийт хөрөнгөтэй ийм сан байгаа. Энэ дотроо бид авлагуудаа насжилтаар нь урт болон богино хугацаат өр төлбөр гэдгээр нь ангилчихсан байж байгаа. Цэвэр хөрөнгөө бол Засгийн газрын оруулсан капитал, хуримтлагдсан үр дүн, хөрөнгийн дахин үнэлгээний зөрөө гээд ингээд дотор нь ангилаад задалчихсан байж байгаа.

2023 ОНЫ 03 ДУГААР САРЫН 21-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

Г.Тэмүүлэн: Сүүлийн нэг асуултад тодруулах нэг зүйл ийм байна. Тусгай сангийн тухай хуулиар 5 дугаар зүйл дээр тусгай сан байгуулах, тусгай санг татан буулгах үндэслэлүүд байгаад байгаа юм. Тэгэхээр та бүхний хувьд энэ тусгай санг ямар үндэслэлээр татан буулгах гэж байгаа гэж үзэж байгаа юм бэ? Энэ 5.6 дээр заасан заалтуудаас 5.6.1-ээс 6.5-ын хооронд гэдэг юм уу, ямар зүйл, заалтаар энэ ер нь санг татан буулгах ёстой гэж үзэж байгаа. Энэ хуулийнхаа дагуу болоод энэ холбогдох журмынхаа хүрээнд процесс нь явсан уу, эсвэл төрийн захиргааны төв байгууллага санхүү төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь хянаж дүгнэлт гаргана гэсэн байгаа юм. Энэ дүгнэлтүүд нь гарсан юм байгаа юу.

Болорчулуун дарга.

Ц.Болорчулуун: Тэмүүлэн гишүүний асуултад нэмэлт хариулт өгье. Тэгэхээр ЗГ-ын тусгай сангийн тухай хууль дээр энэ ЗГ-ын тусгай санг татан буулгах процесс юу нь заалтууд байгаа. Тэгэхээр энэ 5.6 дахь зүйлийн 5.6.3 дахь заалт буюу үйл ажиллагаа нь доголдсон гэдэг энэ заалтыг баримталж байгаа. Үүнийг яагаад баримталж байна вэ гэхээр сан дээр бас тодорхой хэмжээний шалгалтууд жилдээ бараг жилийг тойрсон шалгалтын дунд үйл ажиллагаа явуулдаг. Тухайлах юм бол Сангийн яам, ЭЦГ, АТГ гээд Мөрдөн байцаах газар гээд бүх газруудаас Үндэсний Аудитын ерөнхий газар гээд шалгалтууд явагддаг. Энэ шалгалтуудын үр дүнд хамгийн сүүлд Сангийн яам ХХААХҮЯ-ны хамтарсан шалгалтын үр дүнд дээр бас үйл ажиллагаа нь доголдож байна. Тийм учраас цаашидаа энэ сангийн татан буулгаж өөр хэлбэрээр зохион байгуулах нь зүйтэй гэдгээр энэ үндэслэлийг баримталж байгаа. Энэ үндэслэлийг баримтлахдаа хуулийн төслийн үзэл баримтлалд Сангийн яам, Хууль зүйн яам 3-уулаа хамтарч баталсан. Энэ дээр өнөөдрийн үүсээд байгаа нөхцөл байдлын улмаас тус сангийн хөрөнгийн чадвар

доройтож, активын чадвар буурч, эргэлтийн хөрөнгийн хомсдолд орсны улмаас хуулиар хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлэх, үйлдвэрлэлд шаардлагатай дэмжлэгийн нэр төрөл, хүртээмжийг нэмэгдүүлэх, цаашидын хэвийн үйл ажиллагааг явуулах боломжгүй нөхцөл үүсээд байна гэдгээ энэ үзэл баримтлалдаа тусад нь заагаад өгчихсөн байж байгаа. Тийм учраас энэ заалтыг үндэслээд, тэгээд иймээс бол тус сангийн эрх зүйн байдал өмчийн хэлбэрийг зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцүүлэн үүссэн нөхцөл байдалтай уялдуулан өөрчлөх шаардлагатай гэж үзэл баримтлалд тусгагдсан учраас энэ заалтыг баримталж байна.

Г.Тэмүүлэн: Баярлалаа.

Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Хуулийн төслүүдийн үзэл баримтлалтай холбогдуулан үг хэлэх гишүүд байна уу? Алга. Батжаргал гишүүн. Батжаргал гишүүнээр тасалъя.

Ж.Батжаргал: Тийм. Тэгэхээр хэлэлцэх эсэхийг нь дэмжье. Гагцхүү тэр тусгай сангийн хуулийн чиг үүрэгт байж байгаа энэ ХАА-г дэмжих сангийн чиг үүргүүдийг тэр шинээр байгуулж байгаа аж ахуйн байгууллага бүрэн хариуцаж явах асуудлыг тодорхой чиглэл болгож өгөх. Тэгээд энэ технологийн цаг хугацаанд бэлтгэл зохион байгуулалтуудыг бүрэн хангасан байх ийм асуудал бидэнд зайлиггүй шаардлага байгаад байгаа юм. Тийм. Энэ талаас нь би асуудалд хандаж Байнгын хороон дээр энэ хуулиудыг дагуулж тусгайлсан тогтоол гаргах ёстой болов уу. Үүнийг Байнгын хорооны, одоо дэгийн хуулиар яаж зохицуулж болохоор байна вэ? Үүнийг нэг хармаар байна гэж.

2 дахь зүйл, үгүй ээ бид ер нь төрийн өмчтэй компаниудаа тааруухан ажиллаж байна. Олон нийтийн засаглалтай болгоё оо гэдэг юм маш их

2023 ОНЫ 03 ДУГААР САРЫН 21-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

ярьж байгаа улсууд аа. Тэгвэл энэ төрийн өмчтэй компанийг малчид, фермер, тариаланчдын оролцоотойгоор байгуулах асуудлыг л бид бодмоор байгаа юм, ер нь. 34-өөс доошгүй хувийг нь энэ улсуудын хувьцаа хэлбэрээрээ тийм, байж байдаг. Нэгэнт угаасаа энэ компаниар дамжуулж хийгдэж байгаа бүхий л үйл ажиллагаанууд буцаад яг үйлдвэрлэл эрхэлж байгаа тэр малчид, тариаланчид, эрчимжсэн аж ахуй эрхлэгч нартаа очиж байгаа учраас үнэ өртгийн гэдэг юм уу янз бүрийн юмнууд яригдаад хоорондоо зөрчил үүсээд байхааргүйгээр хийх асуудал бол хамтын оролцоотой компанийн хэлбэр байж байж илүү зохилтой. Үнэ өртгийн асуудал нь өндөр байвал буцаад ноогдол ашиг хэлбэрээрээ очих юм нь нэмэгдэх л байх. Тулгаад хийдэг зарчмаараа явах юм бол анхны бараа материалын гэдэг юм уу энэ нийлүүлэлтийнх нь үнэ ханшууд арай хямд л байх байх. Буцаад технологийн цаг хугацаанд нийлүүлэгдэх ёстой юмнууд ямарваа нэгэн байдлаар доголдохгүй байх ийм бололцоо, боломж, хяналт нь бүрдэх ёстой юм биш байгаа даа.

Тийм учраас дагуулж гарах гэж байгаа тэр тогтоол дотор бас нэг заалт нь бол шинээр байгуулж байгаа ААН-ээ тэр цаад үндсэн хэрэглэгч болсон малчид, тариаланчдынхаа оролцоотой байгуул гэдэг ийм чиглэл юмыг нь өгч ингээж менежментийг нь сайжруулах, үр өгөөжийг нь дээшлүүлэх, олон нийтийн оролцоог хяналттай болгох арга хэмжээг авч хэрэгжүүлж байж, ХАА-н салбар бүхэлдээ жоохон урагшаа алхах болов уу гэсэн ийм л бодол байна аа.

Г.Тэмүүлэн: Ойлголоо. Гишүүд үг хэлж дууслаа. Батжаргал даргын саналтай бас хувь хүнийхээ үүднээс санал нэг байна. Тэгэхээр бид нар Байнгын хорооны зүгээс ч гэсэн энэ асуудлыг хэлэлцэх эсэхийг нь шийдээд тодорхой тогтоолын төслийг санаачилж, ингээд дагалдуулж бас баталъя гэсэн саналтай байна.

Тэгээд энд ирсэн бас яамны удирдах албан тушаалтнууд ч гэсэн та бүхэн бас анхаараарай. Ер нь бид нар энэ төрийн оролцоо болоод төрийн энэ зохицуулалтыг тодорхой хэмжээнд хязгаарлах, тодорхой зах зээлийнх нь зарчимтай нь уялдуулж, хувийн хэвшилтэйгээ хамтарч мэргэжлийн холбоод, төрийн бус байгууллагуудтайгаа хамтарч тэд нарын эрх ашгийг хамгаалдаг ч гэдэг юм уу. Ийм компанийн хэлбэр лүү өмч хэлбэрийг нь зөв болгох оролцоог нь зөв болгох юм руу чиглүүлэх ёстой шүү гэдгийг бас эцэст нь анхааруулж хэлье.

Ингээд ийм чиглэлээр бид нар бас тодорхой хэмжээнд энэ бодлогын асуудлыг дэмжиж байна гэж ойлгож байна.

Ингээд санал хураалтыг явуулцаая. Санал хураалт. Хэлэлцэх эсэхийг дэмжье гэсэн саналаар санал хураалт явуулна.

Даваасүрэн гишүүн төхөөрөмж гацсан уу. Та санал гаргачих.

Ц.Даваасүрэн: Миний төхөөрөмж гацчихлаа, дахиад санал хурааж өгнө үү.

Г.Тэмүүлэн: Саяын санал хураалтыг хүчингүй болгоё гэсэн саналаар санал хураалтыг явуулъя. Санал хураалт.

Саяын санал хураалт хүчингүй боллоо. Ингээд ЗГ-ын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн ЗГ-ын тусгай сангийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналаар санал хураалтыг явуулъя.

Даваасүрэн гишүүн санал хураалт.

2023 ОНЫ 03 ДУГААР САРЫН 21-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

Таных дахиад бас ажиллахгүй байна. Та төхөөрөмжөө солиод үзэх үү. Болж байна уу, та саналаа гаргачих.

Ц.Даваасүрэн: Энэ яагаад дахин дахин хураагаад байгаа юм. Түрүүн хураагаагүй юм уу.

Г.Тэмүүлэн: Хүчингүй болгохыг нь хураасан юм. Таныхаар.

Ц.Даваасүрэн: Тэгвэл дахиад санал хурааж өгнө үү.

Г.Тэмүүлэн: Төхөөрөмж ажиллаагүй учраас гэж байна аа. Саяын санал хураалтыг хүчингүй болгох санал хураалтыг явуулъя. Санал хураалт.

Өмнөх санал хураалт хүчингүй болсон тул ЗГ-ын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн ЗГ-ын тусгай сангийн хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг нь дэмжье гэсэн саналаар санал хураалт явуулъя.

Гишүүд анхааралтай байгаарай. Санал хураалт.

Санал хураалт 60 хувиар дэмжигдлээ.

Ингээд хуулийн төслүүдийг хэлэлцсэн талаар Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг нэгдсэн хуралдаанд УИХ-ын гишүүн Батсуурь гишүүн. Батсуурь гишүүн та танилцуулчих уу. Санал, дүгнэлтийг чуулган дээр. Батсуурь гишүүн танилцуулна аа.

Ингээд ЗГ-ын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн ЗГ-ын тусгай сангийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслүүдийг хэлэлцэж дууслаа.

Ингээд Байнгын хорооны хуралдаанаар өнөөдөр хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан хаасныг мэдэгдье.

Гишүүдэд баярлалаа.

Дууны бичлэгээс буулгасан:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ
ШИНЖЭЭЧ

П.ОЮУНГЭРЭЛ